

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

INCREASE OF MASS MEDIA PARTICIPATION IN CRIME PREVENTION



Ж.БУЯНЦЭЦЭГ

Ачит Ихт ХХК-ийн Хүний нөөцийн ажилтан

BUYANTSETSEG J.

Officer of the Human Resources, Achit Ikht LLC

Товч агуулга: Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь одоо үед мэдээлэл дамжуулах гол эх сурвалж гэдэгтэй хүн бүр санаа нэгдэнэ. Насны хязгаар, газрын байршил зэргээс үл хамааран мэдээллийн хормын дотор түгээх боломжийг бүрдүүлж байгаа нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн онцлог юм. Энэхүү асар хурдацтай хөгжиж буй хэрэгслээр дамжуулан бид "гэмт хэргээс урьдчилан сэргийлэх"-д ашиглах нь бодит эерэг үр дүнд хүргэх бүрэн боломжтой.

Abstract: In nowadays everyone agree that the social media is the main source of information. Media's features are age unlimited, the location doesn't apply and information transfer within seconds. This media is developed quickly and we can use it for crime prevention. It can be real positive beneficial.

Түлхүүр үгс: Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, гэмт хэрэг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх.

Key words: Media, Crime, Crimes Prevention.

Нийгмийн хөгжил цаг хугацааны явцад харилцан адилгүй замналаар хөгжсөөр ирсэн. Нийгмийн хөгжлийн түвшин бүрт харилцан адилгүй хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээллийг авч байлаа. Орчин үед буюу одоо хэвлэл мэдээллийн хэрэгслийн төрөл олширч нас, боловсролын түвшин, газарзүйн байршил гэх мэт бусад хүчин зүйлээс хамааран мэдээллийг олон нийтэд хүргэж байна. Мэдээллийн эх сурвалж нь албан болон албан бус эх сурвалжаар мэдээллийг түгээж, нийгмийн сэтгэлзүйд хүчтэй нөлөөлөл үзүүлж байгаатай маргах хүн байхгүй.

Мэдээлэл дамжуулах хэрэгсэл үүсэж хөгжсөн нь хүн төрөлхтний түүхийн хамгийн сонирхолтой хуудасны нэг

билээ. Дэлхий дахинд тогтмол хэвлэл 300 жилийн турш олон нийтийн мэдээллийн хэрэгслийн үүргийг дангаараа гүйцэтгэж байсан бөгөөд кино, радио, телевиз бий болсноор олон нийтийн мэдээллийн хэрэгслийн цоо шинэ систем бий болжээ. Олон нийтийн мэдээлэл нь дөнгөж XIX зуунд эхлэн үүсэж, XX зуунд хурдацтай хөгжив.

Энэ талаарх тоо баримтыг жишихэд хүний яриа 5000 жилийн өмнө, бичиг үсэг 4 мянга гаруй жилийн өмнө үүсэж, барлах суурь машин 500 жил, харилцах утас 100 жил, радио 60 жил, олон нийтийн телевиз 30 жил, компьютер 25 жил, холбооны хиймэл дагуул 10 гаруйхан жилийн өмнө үүссэн



ХҮҮЛЬ САХИУЛАХУЙ



юм. Хэдэн жилийн өмнө ХБНГУ-д ийм туршилт хийжээ, сэтгэл зүйчид нэг жилийн турш телевизийн нэвтрүүлэг үзэхгүй байвал шагнал олгоно гэж хэсэг хүмүүсийг хамруулжээ. Нийт 184 хүн туршилтад хамрагдаж гурван долоо хоногийн дараа эхний хүн амласнаасаа няцаж, 5 сарын дотор бусад бүх хүн туршилтад оролцохоо больж амласан шагнал авч чадаагүй байна¹. Энэхүү судалгаанаас харахад хэвлэл мэдээллийн хэрэгсэлгүйгээр хүн төрлөхтнийг төсөөлөх боломжгүй байгаа нь харагдаж байна.

Судлаач миний зүгээс хэвлэл мэдээллийн хэрэгслийг дараах 4 төрөлд ангилан үзэж болохоор байна Үүнд:

1. Радио
2. Сонин
3. Телевиз
4. Интернет

РАДИОГИЙН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

1999-2009 онд радиогийн тоо 3 дахин буюу 24 байснаа 76 бол өсчээ. 1999 онд үндэсний хэмжээнд МҮОНР радио, хотод 7 радио, хөдөөд 16 радио үйл ажиллагаа явуулдаг байжээ. 2009 онд Үндэсний хэмжээнд МҮОНР, хотод 24, хөдөө 51 радио болж нэмэгдсэн байна. Радиогийн өсөлт 2007 он хүртэл өсч түүнээс хойш тогтворжсон. Энэ салбарт ажиллагсдын тоо радиогийн тоог дагаад өсөх үед нь өсч, харин тогтворжих үед нь буурсан байна. 1999 онд радиод 348 хүн ажиллаж байсан бол 2007 онд 623 болж өссөнөө 2009 онд 490 болж буурсан. 2008 оноос радиогийн сэтгүүл зүйн бүтээлч ажилтны тоо буурах хандлага ажиглагдсан. 10 жилийн өмнөхтэй харьцуулбал радиогийн 40-с дээш насныхан эрс буурч, 20-30 насныхан энэ салбарыг авч яваа юм.

2004 оноос төрийн байгууллагын эзэмшдэг радиогийн тоо буурч, хувийн эзэмшлийн радио эрс өссөөр 2009 онд 54 болжээ. Энэ 10 жилийн өмнөхөөс 5,4 дахин өссөн үзүүлэлт юм.

¹ Кашлев Ю.Б. Олон нийтийн мэдээлэл, олон улсын харилцаа. 4-5 дахь хуудас. УБ., 1987.

2007 он хүртэл радио сонсогчид нэмэгдэх хандлагатай байсан боловч 2008 оноос буурах хандлага ажиглагдаж байна.

СОНИНЫ ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

2008 онд 130 сонин үйл ажиллагаагаа тогтвортой явуулж байгаа нь өнгөрсөн оноос 30 гаруй сониноор буурчээ. Сүүлийн үеийн судалгаагаар өдөр тутмын болон 7 хоног тутмын сонины тоо нэмэгдэж, түүнээс бага давтамжтай сонины тоо буурах хандлага ажиглагдаж байна. Мөн сонины борлуулалтын тоо өмнөх жилээс гурван сая гаруй ширхгээр буурсныг интернетийн хэрэглээ нэмэгдсэнээр сонины хэрэглээ буурч байгаа, залуучуудаас илүү дунд насныхан сонин уншдаг учир шинэ залуу уншигчдыг бэлтгэх хэрэгцээ шаардлага тулгарч байгаа, мөн шар болон сенсаацитай мэдээлэл бүхий чөлөөт сонины эрэлт эрс буурсан зэрэг олон хүчин зүйлтэй холбон тайлбарлаж болох юм. Ер нь сүүлийн жилүүдэд сонины борлуулалт жилд дунджаар таван хувиар тогтмол буурч байгаа. Энэ нь өдөр тутмаас бусад давтамжтай сонинд хамаарч байгаа юм. Харин өдөр тутмын сонины борлуулалт жил бүр нэмэгдэж, 2008 онд өмнөх оноосоо 3 сая гаруй ширхгээр өссөн үзүүлэлттэй байна. Дэлхийн сонины зах зээлийг ажиглахад өдөр тутмын сонины ноёрхол бий болж, өндөр хөгжилтэй улс орны сонины борлуулалтын 80-90 хувийг өдөр тутмын сонинууд эзэлж байна. Энэ үзэгдэл ч манайд давтагдаж жилдээ 24,5 сая ширхэг сонин борлогддогтоос 1,6 сая буюу 70 орчим хувийг өдөр тутмын 15 сонин борлуулж байгаа юм. Нийслэлчүүдийн тал хувь нь дор хаяж 7 хоногт нэг удаа сонин уншдаг бол сэтгүүлийг 29 хувь нь тогтмол уншиж байна. Гэвч өдөр тутам сонин уншдаг хүмүүсийн тоо өмнөх оны мөн үеэс 1,3 хувиар буурч харин сэтгүүлийг өдөр бүр ашигладаг хүмүүсийн тоо 3,5 хувиар өсжээ.

ТЕЛЕВИЗИЙН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

2009 оны эхний байдлаар орон



МОНГОЛЫН
ХУУЛЬ
САХИУЛАХ
УРСАЛ

даяар 6, Улаанбаатарт 18, орон нутагт 44 телевиз үйл ажиллагаагаа явуулж байв. Сүүлийн дөрвөн жилд телевизийн тоо огцом нэмэгдэж, жилдээ дунджаар өргөн нэвтрүүлгийн дөрвөн телевиз шинээр байгуулагдаж байлаа. Ялгарал багатай олон телевиз бий бий болсноор үзэгчдийг хувааж улмаар нэг телевизэд ногдох үзэгчдийн тоо буурч, орлого буурах хандлага телевиз бүрт ажиглагдаж эхэлсэн. Өөрөөр хэлбэл, 1 сая орчим хүн дөрвөн телевизийг үздэг байсан бол өнөөдөр 15-16 телевизээс сонгож үзэж байна. Энд эрэлтээсээ давсан нийлүүлэлт, ялгарал багатай хэт олон бүтээгдэхүүний бөөгнөрөл, үзэгчдийн төлөөх өрсөлдөөн, хэт их мэдээлэл байгаа юм.


ИНТЕРНЕТИЙН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

Нийт айл өрхийн дотоодын мэдээ мэдээлэл авдаг чухал эх сурвалжуудын нэг телевиз хэвлэл мэдээлэл хэрэглэгчдийн судалгаа эхэлж асан 2003 онд 91,0 хувьтай ноёлох сегмент байсан бол 2008 онд 9 сард 66,5 хувьтай болж үнэмлэхүй доошлосон дүр зураг харагдаж байна. Мөн сонин

эрхлэгч нь Улаанбаатар хотод, 35 үйлчилгээ эрхлэгч нь хөдөө орон нутагт интернетийн үйлчилгээ хүргэж байна. Тус хороо нь Мэдээлэл, харилцаа холбооны салбарын статистик мэдээ, мэдээллийг нэгтгэх ажлын хүрээнд интернетийн үйлчилгээ эрхлэгчдээс бүртгэлтэй гэрээ бүхий интернет хэрэглэгчийн тоог 2014 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэж үзэхэд 227,735 хүрээд байна (Интернет хэрэглэгчийн тооны судалгаанд үүрэн телефон холбооны 3G сүлжээ ашиглан интернет ашиглаж буй хэрэглэгчийн тоо ороогүй болно). Өнөөдрийн байдлаар үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч Мобиком корпораци ХХК, Скайтел ХХК, Юнител ХХК, Жи-Мобайл ХХК-иудын 3G (GPRS, EDG, EVDO) сүлжээнд нийт хэрэглэгчийн тоо 2014 оны жилийн эцсийн байдлаар 1,734,414 хүрээд байна. Нийт интернет хэрэглэгчдийн 83.51 хувь нь Улаанбаатар хотод, 12.69 хувь нь аймгийн төвүүдэд, 3.80 хувь сумдын төвүүдэд байна².

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нийгмийн хөгжлийн явцад харилцан адилгүй зонхилж байсан дараах судалгаанаас харагдаж байна. Үүнд:

Хэвлэл мэдээллийн хэрэгслэл



47-30,8, радио 34-9,3 хувь болж буурсан бол интернет 9-өөс 19,6 хувь, сэтгүүл 3-аас 7,1 хувь болтлоо огцом өсчээ. Интернетийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт 59 аж ахуйн нэгж 2015 оны 01 сарын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаагаас 12 үйлчилгээ эрхлэгч нь Монгол Улсын нутаг дэвсгэрт, мөн 12 үйлчилгээ

2008 оноос эхлэн сонины тоон бууралт өнгөрсөн жилүүдэд харьцангуй тогтвортой хадгалагдаж байсан бол сүүлийн 2 жилд буурчээ.

Хэвлэлийн хүрээлэн мониторингийн тайланд 2011 оноос эхлэн мэдээллийн вэб сайтуудын талаарх мэдээллийг

² Монголын хэвлэл мэдээллийн хүрээлэн, мэдээлэл судалгааны алба -2009. 2015.

оруулж ирсэн. Тус онд хамгийн хүртээмжтэй 30 сайтыг оруулж байсан бол, 2014 онд хамгийн хүртээмжтэй 90 сайтын мэдээлэл оруулсан байна³.

Дээрх судалгаанаас харахад интернет, Вэб сайтын хэрэглээ тогтмол өсөх хандлага ажиглагдаж байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаа нь, нийгмийн мэдээлэл авч буй эх сурвалжтай харилцан хамааралтай. Үүнээс дүгнэхэд нийгмийн мэдээллийн эх үүсвэрийг тодорхойлж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааг явуулах нь илүү үр дүнд хүрэх боломжтой. Дараах баримтаас мэдээллийн эх сурвалжийн зонхилох хэрэгслийн тоо баримттайгаар нийтэлсэн байна.

Баримт өдрийн сонины 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 17 дугаар хуудсанд хэвлэгдэн гарсан мэдээлэлд дурдсанаар: Монголын хэвлэлийн хүрээлэнгээс өчигдөр 2014 онд хэвлэл мэдээллийн хэрэгсэлд гарсан өөрчлөлтийн талаар мэдээлэл хийв. Тус мэдээллээр өнгөрсөн онд хэвлэл мэдээллийн хэрэгслэлд томоохон өөрчлөлтүүд гарчээ. Жишээлбэл: 1999-2012 онд хэвлэл мэдээллийн тоо 197-450 болтлоо нэмэгдэж байсан аж. Гэтэл сүүлийн хоёр жилд 411 болтлоо буурчээ. Ингэснээр энэ хэмжээгээр мэдээллийн борлуулалт ажлын байр багассан байна. Нийслэлд өнгөрсөн онд зургаан телевиз хаалгаа барьсан бол сонины тоо 11-ээр буурсан дүн гарчээ. Харин сайтын хувьд тасралтгүй өссөөр байна. 2011 онд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 30 сайт байсан бол өдгөө энэ тоо 92-т хүрсэн байна. Харин нийт мэдээллийн хэрэгслийн 30 хувийг эзэлдэг орон нутгийн мэдээллийн хэрэгслийн чанар, гаралт сайжрах болжээ. Зах зээл нь бага зэргээр тэлэх хандлага ажиглагдсан байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоогоор Орхон, Дархан-Уул, Хөвсгөл аймаг тэргүүлж байна. Мөн цахим сүлжээг ашиглах хэвлэл мэдээллийн тоо эрс нэмэгджээ. Нийт хэвлэл мэдээллийн хэрэгслийн 44 хувь нь фэйсбүүк хуудастай, 35 хувь

нь байгууллагын сайттай, 18 хувь нь твиттер нээн жиргэж, телевизүүдийн 39-49 сувгийг иргэд онлайнаар үзэж байна⁴.

Нийгмийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийтлэл, нэвтрүүлгийн тусламжтайгаар үнэн бодитой мэдээллээр шуурхай, тогтмол хангах зорилго бүхий тогтмол хэвлэл, радио, телевиз, мэдээллийн агентлаг, баримтат кино, цахим хэвлэл зэрэг мэдээллийн сувгийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл гэж нэрлэдэг. Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн мэдээлэл нь үнэн бодитой, тогтмол, шуурхай, хүртээмжтэй, багтаамж сайтай, идэвхтэй, ашигтай, чиглэсэн зорилготой байх зэрэг шинжээрээ бусад төрлийн мэдээллээс ялгардаг.

Орчин үед цахим хэвлэл эрчимтэй хөгжиж, мэдээллийн шинэ орон зай, боломжийг нээж, хэрэглэгчдийн тоо эрс нэмэгдэж байна. Мэдээллийн хэрэгсэл болгон өөрийн гэсэн давуу болон сул талтай, онцлог шинж, давуу талын ачаар мэдээллийн зах зээлд орон зайгаа эзэлж, байнгын хүлээн авагчаа бий болгож, өрсөлдөх шинэ боломжийг эрж хайдаг, нийтлэл, нэвтрүүлгийг агуулга хэлбэр, ур чадвар, арга барилын хувьд үргэлж шинэчилж, хөгжүүлэн баяжуулж байдаг. Энэ нь оршин тогтнох, амьдрах чадварын эх үндэс болдог байна.

Дэлхийн зарим улс орон техник технологийн хөгжлийг тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд ашиглаж, үр дүнд хэдийнээ хүрсэн байна. Улс орнууд цахим нийгэм бүтээн байгуулж байна. Иргэд нь гэрээсээ гарахгүйгээр сонгуульд саналаа өгч, бүх төрлийн тайлан, мэдээ бэлтгэн, холбогдох маягт, гэрээ хэлцэл дээр гарын үсгээ гар утаснаасаа зурж, онлайн худалдан авалтыг цахим хаягаар гүйцэтгэж, компаниа хэдхэн минутын дотор бүртгүүлж, хөрөнгө болон холбогдох хуулийн мэдээллийг гар утсаараа шалгаж, бүтээгдэхүүн, үйлчилгээ төр засаг нь баталгаажуулан, интернетээр аюулгүй борлуулж байна.


Нийгмийн хөгжлийг дагаад гэмт

³ Хэвлэлийн хүрээлэн Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр. 2015.

⁴ Өдрийн сонин 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн нийтлэл 17- хуудас. Х.Бат



МОНГОЛЫН ХҮҮЛЬ
САХИУЛАХУЙ



хэргийн төрөл олширч, гэмт хэрэг гаралтын тоо буурах хандлагагүй байгаа нь судалгаанаас харагдаж байна. Улсын хэмжээнд 2015 оны эхний 4 сард 10451 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 1332 хэрэг буюу 14.6 хувиар өсчээ.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн эхний 4 сарын байдлаар


Сэжигтэн нь тодорхойгүй байсан 5252 хэргийн 2875 буюу 54.7 хувийнх нь холбогдогч нь тогтоогдож, яллагдагчаар татагдсанаар гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд өмнөх оны мөн үеийнхээс 1.5 пунктээр өсч, харин нийслэлийн хэмжээнд 0.7 пунктээр буурсан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан

хэмжээ 53.0 тэрбум төгрөг буюу 3.3 дахин, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 3.3 тэрбум төгрөг буюу 38.2 хувиар өссөн⁵.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Нийгэм өөрөө ийм бухимдалтай, шударга бус явдал газар авсан, нэмээд машины түгжрээ, утаа, хүмүүсийн зохисгүй харилцаа гээд олон асуудал тэднийг бухимдуулдаг. Гэртээ ирээд зурагт асаалаа нийгмийн хар бараан, сүүдэртэй, аль болох болж бүтэхгүй бүхнийг харуулсан мэдээ, мэдээллээр бөмбөгдөнө. Хүн амины хэрэг, хулгай, дээрэм, ослын талаар мэдээлэл телевизээр үзээд та яаж хүлээж авдаг вэ? гэсэн судалгааг явуулахад оролцогчдын



хохирлын хэмжээ, жил бүрийн эхний 4 сарын байдлаар, тэрбум төгрөг

Цэнхэр - нийт хохирол

Улаан - Нөхөн төлүүлсэн

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2015 оны эхний 4 сард 75.7 тэрбум төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 12.0 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс учирсан хохирлын

80 гаруй хувь нь цочирддоггүй, энгийн үзэгдэл мэтээр хүлээж авдаг хэмээн хариулсан байна. Үүнээс үзэхэд энэ бүхэн нь нийгэмд байдаг л нэг үзэгдэл мэт болжээ. Хүмүүсийн цочирдохгоо больсон, дассан зохицсон учир энэ нь нийгэмд эргээд хууль бус явдлыг улам

⁵ Olloo.mn 2015 оны 5 сарын 13-ны өдрийн нийтлэл.



дэврээдэг байна. Нийгэмд хулгай, хүний амь нас хөнөөсөн хэрэг буурахгүй байгаа нь бас нэг талаас сэтгүүлчид, ХМХ—тэй холбоотой байж болно. Тухайлбал, дахиад энд ингэж дэлбэрэлт боллоо, хүний амь нас бүрэлгэлээ, сувгаа солиод дээрэмчид дайрсан байна, ажилгүйдэл газар авч байна, хулгайд алдлаа. Хэт улс төржсөн мэдээлэл, хэт нэг намыг шууд сурталчилсан мэдээ, засгийн газрын ордны хэрүүлийг үзнэ. Аль эсвэл халуун тогоо, дотуур хувцас зэргийг сурталчлаад явчихна. Ингээд тэд зурагтаар үзэх нэвтрүүлэг алга гэдэг.

Сэтгүүлчид дээрх хар бараан мэдээллээ үзэгчдэд хүргэснээр тэдний анхаарлыг татаж, нөгөө хэлээд байгаа “Watch dog” буюу ард түмний “хоточ нохойн” үүргээ биелүүлж байна хэмээн андуурдаг. Нийгэмд “сенсаци” тарлаа өөрийгөө цахиур хагаллаа, онц ноцтой мэдээ үзүүлснээр сэтгүүлзүйн үүргээ ягчлан биелүүллээ хэмээн эндүүрдэг. Сэтгүүлзүй гэдэг бол мэдээж хэрэг нийгэмд гараад буй аливаа асуудлыг илчлэх зорилготой боловч нийгэмд болж буй сайн сайхныг харуулах нь ингэснээрээ тэднийг гэгээрүүлэх хамгийн чухал үүргээ умартаж байна. Чухал үүрэг болох энэхүү нийгмийг соён гэгээрүүлэх, төлөвшүүлэх, нийгмийн сэтгэлзүйг эрүүлжүүлэх, тайвшруулах гэдэг үндсэн үүрэг нь хаана байна. Манай улсын сэтгүүлзүйн зорилго нь аль болох л ард түмнийг айлгасан мэдээллийг хүргэж байхыг хичээдэг. Түүний л төлөө ажилладаг бололтой. Нийгмийг тайвшруулах тэдэнд чиглэсэн, сэтгэл санааг амраасан бодол эргэцүүллийг өгсөн мэдээллийг хүргэх хэрэгтэй билээ. Сэтгүүлзүй ард түмнийг гэгээрүүлэх Нийгмийн сэтгэлзүйг эрүүлжүүлэх, зорилго бүхий нийтлэл нэвтрүүлэг дутмаг байх шинжтэй Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаанд голлон анхаарахгүй

байгаа тал ажиглагддаг. Үүний илрэл нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ тогтмол бус шинж чанартай хэрэгждэг, урьдчилан сэргийлэх ажиллагааны үр дүнг нарийн тооцож хэрэгжилтэд анхаардаггүй гэх талууд түгээмэл ажиглагддаг.

Эдгээрээс хархад телевизийн нийтлэл, нэвтрүүлэг нь нийгмийн бүхэл хэсгийн оюун санааны хэрэгцээг хангаж чадахгүй байна гэсэн дүгнэлтэд хүрч болно. Үүнд: Сэтгүүлчийн мэдлэгийн түвшин - Сэтгүүлчид мэдлэг боловсрол хомсоосоо болоод аливаа асуудлыг задлан шинжлэх, буцаагаад нэгтгэн дүгнэдэггүй. Шууд л дамжуулдаг, ингэснээр нийгмийн оюуны хэрэгцээг хангадаггүй. Бодол эргэцүүлэл, ухаарал хайрласан нэвтрүүлгийг бэлтгэх нь чухал юм. Мөн сэтгүүлчийн боловсролоос үл хамааран сэтгүүлчийн ёс зүйн тухай асуудал гардаг. Сэтгүүлч ямагт ард түмний эрх ашгийг эрхэмлэх ёстой. Ямарваа нэгэн нам хүчин, хэсэг бүлгийн эрх ашгийн төлөө үйлчилдэг, аливаа асуудлыг хэт улс төржүүлдэг билээ. Иймээс сэтгүүлчийн ёс зүйг ухамсарлах, түүнийг нэн тэргүүний шалгуур болгох нь чухал юм. Юуг хүргэх вэ? Энэ асуудал хамгийн чухал юм. Таарсан мэдээ болгоныг телевизээр цацаад байх уу? Нийгэмд ямар ач холбогдолтой, тэдэнд хэрхэн нөлөөлөх зэргийг ухамсарлах нь чухал. Өнөөгийн телевизийн мэдээлэл нь гэгээрүүлэхээс илүү сөрөг дагаврыг бий болгоно. Сэтгүүлч мэдээллийн үр дагаврыг тооцоолдог байх шаардлагатай юм.

Судалгаанаас хархад хэвлэл мэдээллийн хэрэгсэлгүйгээр нийгмийг төсөөлөх боломжгүй байгаа талыг эерэгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шаардлага бидний өмнө байгааг дахин сануулмаар байна.

**Уншиж танилцан нийтлэхийг зөвшөөрсөн:
Сэтгүүлийн зөвлөлийн гишүүн, цагдаагийн ахмад Г.Оюунболд**